



**НИЙСЛЭЛИЙН
НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 6/08


Улаанбаатар хот

Б.Бадамдоржид цалинтай чөлөө,
буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйл, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/817 дугаар захирамжаар батлагдсан “Нийтийн тээврийн үйлчилгээний газрын дүрэм”-ийн 2.5.3, Хөдөлмөрийн дотоод журмын 6.19.1, 7.3.10-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ :

1. Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтсийн ажлын гүйцэтгэлийн хяналтын мэргэжилтэн Батжаргал овогтой Бадамдоржийн төрсөн эгч нь нас барсан тул 2020 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс 13-ны өдрийг дуустал ажлын 5 хоногийн цалинтай чөлөө, буцалтгүй тусламж олгосугай.
2. Буцалтгүй тусламжид зарцуулагдах 100000 /Нэг зуун мянга/ төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас тооцож олгохыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн ахлах нягтлан бодогч /Э.Эрдэнэтуяа/-д зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч /Б.Монголмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР